



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/30 дуга-2018/10/СТА-ТЧЗ

Мандалговь хот

Г

Төлбөр барагдуулах тухай

7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Уламжлалт анагаах ухааны төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар ажил хавсарсны нэмэгдлийг үндсэн албан тушаалын цалингаас тооцон **405,631.0 /Дөрвөн зуун таван мянга зургаан зуун гучин нэгэн/ төгрөгийн цалингийн нэмэгдлийг илүү олгосон.**

Эн нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т /Батлагдсан цалингийн сан орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2-т /Ажилтан үндсэн ажлынхая зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтын үүргийг орлон гүйцэтгэсэн ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү пагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огех, хувь тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжсүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огох/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-д /Бусдад огех төлбөр тооцоог зөрүүтэй тооцоожуулсан/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Илүү тооцож олгосон **405,631.0 /Дөрвөн зуун таван мянга зургаан зуун гучин нэгэн/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 10008000955 дугаар дансанд 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх;**
- Актын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Уламжлалт анагаах ухааны төвийн дарга Х.Чирчинсүрэн, нягтлан бологч У.Цэвэгмэд нарт хариуцуулав.

ТОГТООСОН: АУДИТОР <i>Д.ОЮУН-ЭРДЭНЭ</i>	АКТЫН: ЗӨВШӨӨГСӨН: ДАРГА <i>Х.ЧИРЧИНСҮРЭН</i> НЯГТЛАН БОЛОГЧ <i>У.ЦЭВЭГМЭД</i>
---	---

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангажаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчийг гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны давуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.